

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/113/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 261885 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Аудитор: П.Ариунзаяа
Утас: 260512 Цахим хаяг: ariunzayap@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит ХХК
Захирал: Ч.Энхтуяа
Цахим хаяг: enkhtuya@hlb.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ БОДЛОГЫН
ДЭМЖЛЭГ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Г.НАРАНГУА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 04/314
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл нь 2 үе шаттайгаар хэрэгжсэн бөгөөд эхний үе шат нь 2015-2019 он, хоёр дахь үе шат нь 2020-2023 он хүртэл хэрэгжсэн. Монгол Улсад төрийн үйлчилгээг илүү үр дүнтэй, үр ашигтай, хүртээмжтэй болгох зорилгоор уг төслийг төрийн бүх шатны байгууллага, бүх салбарыг хамруулан улсын хэмжээнд хэрэгжүүлсэн байна.

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2 дахь үе шатны гол зорилго нь төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой хуваарилах аргачлалыг бүх салбарт засаг захиргааны бүх шатанд хэрэгжүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, сургалт зохион байгуулж, орон нутгийг чадавхжуулах, улмаар төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлыг цаашид төр засгийн тогтвортой хийх ажил болгон нутагшуулахад дэмжлэг үзүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсад засаглалын болон орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдэж байгаа хууль эрх зүйн орчны шинэчлэлийн ажилд тэр дундаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох дүрэм, журмууд, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай болон

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг боловсруулан батлуулахад төслийн зүгээс ихээхэн хувь нэмэр оруулан батлуулж, орон нутгийн чадавхыг дээшлүүлэх чиглэлээр бүх аймаг, сумдад сургалт зохион байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж бүрэн хэрэгжүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	511,681,348.49	1,439,638.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	505,179,934.49	312,529.39
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	389,690.00	1,860.00
31110	Төгрөг	389,690.00	1,860.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	504,790,244.49	310,669.39
31210	Төгрөг	504,790,244.49	310,669.39
31213	Арилжааны банк дахь харилцах	504,790,244.49	310,669.39
35	БАРАА МАТЕРИАЛ	6,501,414.00	1,127,109.00
35400	Хангамжийн материал	6,501,414.00	1,127,109.00
35410	Бичиг хэргийн материал	6,386,070.00	998,568.00
35420	Аж ахуйн материал	115,344.00	128,541.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,303,398.74	12,930.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,303,398.74	12,930.00
39200	Биет хөрөнгө	2,303,398.74	12,930.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,243,182.00	12,243,182.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,034,293.08)	(12,243,182.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,255,881.89	1,255,881.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,161,372.07)	(1,242,951.89)
39300	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	513,984,747.23	1,452,568.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,000,000.00	28,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,000,000.00	28,000,000.00
41300	Өглөг	15,000,000.00	28,000,000.00
41360	Бусад өглөг	15,000,000.00	28,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	15,000,000.00	28,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	498,984,747.23	(26,547,431.61)
51	Засгийн газрын хувь оролцоо	498,984,747.23	(26,547,431.61)
51200	Хуримтлагдсан үр дүн	498,984,747.23	(26,547,431.61)
51210	Өмнөх үеийн үр дүн	309,283,583.22	498,984,747.23
51220	Тайлант үеийн үр дүн	189,701,164.01	(525,532,178.84)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	513,984,747.23	1,452,568.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	830,000,000.00	122,120,938.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	830,000,000.00	122,120,938.88
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,120,938.88
120002	Хүүгийн орлого	-	2,120,938.88
122	Тусламжийн орлого	830,000,000.00	120,000,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	830,000,000.00	120,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	640,298,835.99	647,653,117.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	640,298,835.99	647,653,117.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	640,098,835.99	647,653,117.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,111,000.50	154,311,234.09
210101	Үндсэн цалин	181,391,000.50	132,783,234.09
210105	Гэрээт ажлын хөлс	18,720,000.00	21,528,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,976,435.00	29,198,250.75
210201	Тэтгэврийн даатгал	17,009,435.15	20,104,009.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,001,110.02	2,343,177.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,600,888.01	1,874,542.06
210204	Ажилгүйдлийн даатгал	362,781.82	322,166.58
210205	Эрүүл мэндийн даатгал	4,002,220.00	4,554,355.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,291,694.00	39,445,467.00
210301	Гэрэл, цахилгаан	316,694.00	370,467.00
210304	Байрны түрээс	30,975,000.00	39,075,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,600,512.71	9,567,375.82
210401	Бичиг хэрэг	385,577.27	3,013,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,454,519.44	1,458,261.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	760,416.00	5,095,459.00
2107	Томилолт, зочны зардал	63,044,703.00	31,285,000.00
210701	Гадаад албан томилолт	46,021,703.00	-
210702	Дотоод албан томилолт	17,023,000.00	31,285,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	314,607,698.62	381,555,321.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	298,773,898.62	361,358,236.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	20,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	71,500.00	197,085.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,466,792.16	2,290,468.74
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,466,792.16	2,290,468.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	189,701,164.01	(525,532,178.84)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	189,701,164.01	(525,532,178.84)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	830,000,000.00	122,120,938.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	830,000,000.00	122,120,938.88
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,120,938.88
120002	Хүүгийн орлого	-	2,120,938.88
122	Тусламжийн орлого	830,000,000.00	120,000,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	830,000,000.00	120,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	625,198,010.56	626,988,343.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,198,010.56	626,988,343.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	624,998,010.56	626,988,343.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,111,000.50	154,311,234.41
210101	Үндсэн цалин	181,391,000.50	132,783,234.81
210105	Гэрээт ажлын хөлс	18,720,000.00	21,527,999.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,976,435.00	29,198,250.75
210201	Тэтгэврийн даатгал	17,009,435.16	20,104,009.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,001,109.83	2,343,177.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,600,888.01	1,874,542.06
210204	Ажилгүйдлийн даатгал	362,782.00	322,166.58
210205	Эрүүл мэндийн даатгал	4,002,220.00	4,554,355.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,291,694.00	39,445,467.00
210301	Гэрэл, цахилгаан	316,694.00	370,467.00
210304	Байрны түрээс	30,975,000.00	39,075,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,016,479.44	7,114,190.82
210401	Бичиг хэрэг	426,900.00	250,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,454,519.44	1,507,761.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,135,060.00	5,355,474.00
2107	Томилолт, зочны зардал	63,044,703.00	31,285,000.00
210701	Гадаад албан томилолт	46,021,703.00	-
210702	Дотоод албан томилолт	17,023,000.00	31,285,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	302,557,698.62	365,634,201.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	292,223,898.62	350,437,115.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,500,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	762,300.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	71,500.00	197,085.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	-

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	204,801,989.44	(504,867,405.10)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	204,801,989.44	(504,867,405.10)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	300,377,945.05	505,179,934.49
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	505,179,934.49	312,529.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	309,283,583.22	309,283,583.22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	309,283,583.22	309,283,583.22
Тайлант үеийн үр дүн	-	-	189,701,164.01	189,701,164.01
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	498,984,747.23	498,984,747.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	498,984,747.23	498,984,747.23
Тайлант үеийн үр дүн	-	-	(525,532,178.84)	(525,532,178.84)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(26,547,431.61)	(26,547,431.61)

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,860.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад 2,860.0 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайланд дотоод томилолтын 2,860.0 мянган төгрөгийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд буруу ангилж тайлагнасныг залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасны дагуу албан томилолтын зардлын дансанд залруулан бүртгэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд дотоод томилолтын 2,860.0 мянган төгрөгийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд буруу ангилж тайлагнасан байна.	1	2,860.0	-	-	-	-	1	2,860.0	-	-	-	-
	Дүн	1	2,860.0	-	-	-	-	1	2,860.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант онд 20,520.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгах хариуцлага тооцох албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	20,520.0	-	-	1	20,520.0	-	-		
	Дүн	1	20,520.0	-	-	1	20,520.0				